

“МАШИН МЕХАНИЗМ” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үйлдвэрлэлийн тайлан

“Машин механизм” ХК нь 2016 онд барилга угсралт, өргөн тээвэр, автотээвэр хүнд механизмын үйлчилгээ худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирлээ.

Барилга угсралт: Компани нь 2015-2016 онд Дундговь аймгийн ЗДТГ-ын захиалгатай МСҮТ-ийн 960 суудалтай хичээлийн байр, спорт урлаг заалны барилга, СБД-ийн 2-р сургуулийн өргөтгөлийн нэмэлт ажил, Дундговь аймаг Мандалговь 3000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэнгийн барилгыг гэрээний дагуу барилгын угсралтын ажлыг бүрэн дуусган улсын комисст иж бүрнээр хүлээлгэн өгсөн

Өргөн тээвэр: 2016 онд Ордос ХХК, Өгөөмөр монгол ХХК, ЦЭЭБ ХХК, Эх газар ХХК, Хаппи бьюлдинг ХХК, Жаргалант аураг ХХК- дад цамхагт болон хийн дугуйт кранаар үйлчилж 128 496.8 мян. төг-ийн ажил хийсэн байна.

Тусгай зөвшөөрлийн тухай

Тус компани нь Барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх болон өргөн тээвэрлэх машины угсралт буулгалт засварын ажлын тусгай зөвшөөрөл тус тус эзэмшиж ажилладаг тусгай зөвшөөрөл нь хуулийн хугацаандаа байгаа болно.

Санхүүгийн тайлан

Хөрөнгө: “Машин механизм” ХК нь 2015 оны байдлаар нийт хөрөнгө 4 707 456,4 мян.төг байснаас 2016 онд 4 120 201,2 мян.төг болж нийт хөрөнгө 587 255,2 иян.төг-өөр буурсан, үндсэн хөрөнгө 340532,7 мян.төг байснаас 341832,7 мян.төг болж үндсэн хөрөнгө 1300,0 мян.төг-өөр өссөн, эргэлтийн хөрөнгө 4 475 199,9 мян. төг байснаас 3 918 512,4 мян.төг болж эргэлтийн хөрөнгө 556 687,5 мян. төг-өөр буурсан байна.

Авлага: 2015 онд 157 699,7 мян.төг байснаас 2016 онд 232848,6 мян.төг болж авлага 75148,9 мян. төг-өөр өссөн.

Өглөг: 2015 онд 3 055 479,1 мян.төг байснаас 2016 онд 2 311 841,6 мян.төг болж өглөг 743637,5 мян.төг-өөр буурсан болно.

Ашиг, алдагдал: Тайллангийн хугацаанд борлуулалтын орлого 3 691 785,1 мян. төг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1 865 739,5 мян.төг, үйл ажиллагааны зардал 1 652 287,3 мян.төг үндсэн үйл ажиллагааны ашиг 173 758,2 мян.төг, үндсэн бус үйл ажиллагааны ашиг 0 мян. Орлогын татварын зардал 17 375,8 мян. төг тайлант үеийн нийт ашиг 173 758,2 мян. төг, цэвэр ашиг 156 382,3 мян. төг байна.

МАШИН МЕХАНИЗМ ХК